



ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

БИЧИЛ УУРХАЙ ГЭЖ

Ашигт малтмалын үйлдвэрлэлийн бус агуулгатай, эдийн засгийн үр ашиггүй орд, ашиглалтын болон технологийн хаягдлаар бий болсон үүсмэл орд, илрэл бүхий талбайд ашигт малтмал олборлох зорилгоор явуулж байгаа үйл ажиллагааг хэлдэг.



ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

Монгол Улсын Засгийн Газрын 2010 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 308 дугаар тогтоолоор **“Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох”** журмыг баталсан.

БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДЭД ЗОРИУЛАВ



БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧ ГЭЖ

Иргэний хуулийн 481.1-д заасны дагуу бүртгэгдээгүй нөхөрлөл болон 36.4 заасан хоршооны хэлбэрээр зохион байгуулагдсан иргэдийн эрхэлж байгаа үйл ажиллагааг хэлнэ.

Бүртгэгдээгүй нөхөрлөл гэж Хамтран ажиллах гэрээний үндсэн дээр хэд хэдэн этгээд холбоо болон нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдаж үйл ажиллагаа явуулах юм. Ийм байгууллагыг улсын бүртгэлд бүртгүүлэхгүй, бүтэц, зохион байгуулалтыг гишүүд харилцан тохиролцож тодорхойлно.

Хоршоо гэж эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээгээ хангах зорилгоор хэд хэдэн этгээд сайн дураараа нэгдсэн, хамтын удирдлага, хяналт бүхий дундын эд хөрөнгө дээр үндэслэн үйл ажиллагаа явуулахаар байгуулсан хуулийн этгээдийг хэлнэ.



ОЛБОРЛОХ ГАЗАР

Нэг сумын нутагт Бичил уурхайгаар ашигт малтмал олборлоход зориулан сонгосон газрын тоо 10-аас илүүгүй байна.



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарийн хөгжлийн агентлаг

Нөхөрлөлд эзэмшүүлэх газрын хэмжээ 5 га - аас ихгүй байна. Бичил уурхай эрхлэгч нь орон нутгийн Засаг даргатай гэрээ байгуулж ажиллана.



ХУУЛЬ, ТОГТООМЖ

Ашигт малтмалын тухай хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль болон татварын бусад хууль тогтоомж

ТАНЫ ТӨЛӨХ ТАТВАР



1. АШИГТ МАЛТМАЛЫН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨР
2. ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР
3. ААНОАТ
4. БУСАД

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр (АМНАТ) - ийг ХЭН ТӨЛӨХ ВЭ?

1. Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч
2. Бичил уурхай эрхлэгч, нөхөрлөл, хоршоо



Ашигт малтмалын тухай хуулийн 47-р зүйлийн 47.1.-д “Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уурхайн эдэлбэрээс олборлож худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан болон ашигласан бүх төрлийн бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээнээс тооцож ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг улсын төсөвт төлнө” гэж заасны дагуу Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлнө.



ХУВЬ ХЭМЖЭЭ:

- Монгол банк, түүнээс эрх олгосон банкинд худалдсан Алт - 2.5%
- Дотоодод борлуулж байгаа Нүүрс - 2.5%
- Түгээмэл тархацтай ашигт малтмал - 2.5%
- Үүсмэл ордоос олборлосон ашигт малтмал - 2.5%
- Бусад ашигт малтмал - 5%

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг ногдуулах борлуулалтын үнэлгээг тооцохдоо:

- Экспортод бүтээгдэхүүн гаргасан бол тухайн бүтээгдэхүүний олон улсын зах зээлийн үнийг баримтлана; /Засгийн газрын 2016 оны 81, Засгийн газрын 2015 оны 102, 103, Засгийн газрын 2014 оны 220-р тогтоолуудыг баримтлана/
- Дотоодод борлуулсан буюу ашигласан бол тухайн бүтээгдэхүүний дотоодын зах зээлийн үнийг баримтлана;
- Дотоод, гадаадын зах зээлд борлуулсан бүтээгдэхүүний зах зээлийн үнийг тодорхойлох боломжгүй тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн мэдүүлсэн борлуулалтын орлогыг үндэслэнэ.



Татвар төлөх хугацаа

- Тухайн сард худалдсан ашигласан бүх төрлийн ашигт малтмалын бүтээгдэхүүнд ногдох Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг дараа сарын 10-ны дотор
- Монгол банк болон түүний эрх олгосон банкинд алт, мөнгө худалдсан, тушаасан түхэй бүр Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг тухайн банк суутгаж төсөвт төвлөрүүлэн төлнө.

Тайлагнах хугацаа

- Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн улирлын тайланг дараа сарын 20-ны дотор
- Жилийн эцсийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 20-ны дотор тус тус тайлагнана.

Хүлээлгэх хариуцлага

- Ашигт малтмалын тухай хуулийн 66-р зүйл;
- Татварын ерөнхий хуулийн 74-р зүйл;
- Татварын бусад хууль тогтоомжуудад заасан хариуцлага

Холбоо
барих хаяг:

- ✉ utohg@mta.gov.mn
- 🌐 <http://www.mta.mn>
- 🌐 <http://e-tax.mta.mn>
- 📘 Mongolian taxation
- 📺 Mongolian taxation



Улсын Төсвийн Орлого,
Хяналтын Газар

ТАНЫ ТӨЛСӨН ТАТВАР - ЭХ ОРНЫ ХӨГЖЛИЙН ҮНДЭС